

**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ**  
**ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ**

№18/479

ШУС, НУС

2017

**Б.ЦЭДЭНДАМБААГИЙН ЦЭЦ УХААН**

Д.Батжаргал\*

\*МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Хүмүүнлэгийн ухааны салбарын Утга зохиол, урлаг судлалын тэнхимийн багш, доктор (Ph.D), дэд профессор

**Түлхүүр үг:** аман билиг, радиогийн онцлог, дүрслэлийн хэл, сэтгүүлчийн уран чадвар

**М**онголын радио хэмээх ная гаруй жилийн түүхтэй хэвлэл мэдээллийн “том айл” олон сайн сэтгүүлчдийг бойжуулж, эгнээнээсээ төрүүлэн гаргасан билээ. Ихэнх бүтээлээ тэнгэрээр нэг, агаарын уудмаар цацаад санаа амардаг болохоор шүүж шүүрдэж авахад бэрхтэй. Гэвч хүмүүсийн сэтгэлд хоногшиж, олны чихнээ танил болсон нь олонтаа. Тэдний нэг нь СГЗ, Базарын Цэдэндамбаа агсан. Ихэнх нь Дамбаа хэмээн авгайлна. Тэрбээр алдаж онож, гэнэдэж, бага зэрэг буруудаж явсан ч, давтагдашгүй дуу хоолой, гэнэт тулгарсан цочмог үйлд уран үгийг гайхалтай оноод хэлчихдэг аман билиг сайтай хүн байлаа. Түүний радио сэтгүүлчид байх ёстой онцгой энэ чанарыг нь товойлгон бичсэн хүмүүс бас бий.

Д.Цоодол “Базарын Цэдэндамбаа өгүүлрүүн” бичил хөрөгтөө түүний үгээр “Энэ амьдрал гэдэг чинь шал дэмий богинохон ганцхан төө эд юм. Арван есөн онд байх, манай буриадууд Ононд ирэхдээ ядарч гүйцсэн байлаа. Иргэний дайны шархтай хазгар

*доголон нь ч байсан, орос, монгол, цэрэг хувцастай, унаатай, унаагүй л ирсэн гэдэг. Дайн дажин үймээн самуунаас залхаж, арай тайван амьдрал хүсч ах дүүгээ бараадаж яваа юм. Онон, хатан ээж минь. Орон гэргүй өчнөөн хүн мод бургасны нөмөрт, халхын их нутгийн **тэр олон мөнгөн аяга шиг хонхорт хэвтэж, задгай тэнгэрийн дор унтаж хонож байсан гэдэг. Бидний чадах юм өвс хадах, талх барих, байшин барих байлаа. Халхууд их сонирхож өвс хадуулна, оронд нь нэг төлөг, дүнзэн байшин бариулна, бас нэг бяруу. Тэгээд л манай буриадууд өөдөлж эхэлсэн гэж баавай нар ярьдагсан. Би бол гучин хоёр оны хүүхэд. Намайг гарахад манайх хоёр мянгаад малтай нижгэр айл болчихсон байжээ. Би саяхан л Ононгоосоо шуудай үүрээд гарсан юмсан. Хэдхэн шүлэг, найраглал сараачаад, радиогоор баахан хашгирч, хэдхэн намрын тариа сурвалжлах шиг болсон... нэг мэдэхнээ ийм нэг хэл бултаганасан хөгшин буриад болчихоод сууж байдаг байна”*** гэж ярьсныг тэр чигээр буулгасан байна. Цаг хугацааг бодитчилон гэзэг сур шиг төөлж хэмжинэ гэдэг Цэдэндамбаагаас л

гарах ухаан. Бас Д.Цоодол гуайн бичсэн жаахан бичвэрт, анх хотод ес хонож, зүдэрч зүтгэж ирсэн тухайгаа **“Чоно шиг өлсөж байлаа. Нэг гуанзанд орсон чинь тоглойсон сайхан бууз зарж байна. Хорийг аваад үмхэж гарлаа. Ганц ч мах байдаггүй. Махгүй буузыг мантуу гэдэг юмсанжээ”** гэх юм уу, **“Намайг ирэх үеийн Улаанбаатар одоотой ярих юм байхгүй ээ. Зүгээр л нэвсийсэн хар тосгон байлаа. Хэдэн микрорайон энэ тэр чинь саяхны юм. Хятадын хөнгөн жууз тэрэг баруун зүүн тийшээ намс намс шогшиж, хороо хүрээгээр нэг хөрөө барьсан юмнууд “Мод хөрөөд” гэж хашгирч...”** гэх мэтээр ярьсан байна. Энэ мэтээр өгүүлбэр бүртээ зураг дүрслэлийг бий болгож ярина.

**Д**ээр нь ярианы өргөлт, зогсоц, дуулдац энэ тэрийг гайхалтай мэдэрнэ. Зарим газар чимээгүй болж чадна. Зарим хэсэгт зориуд дуу хоолойгоо өндөрсгөн бага зэрэг буриад аялгаар чанга ярина. Сэтгэлийн хөдөлгөөнөө хүчтэй илэрхийлнэ. Дуу чимээгээр дүрслэх эрдмийг мэргэжлийн түвшинд эзэмшсэн сэтгүүлч. “Ургацын далай” дууны уянга хөгжмийг эгшиглүүлэхийн зэрэгцээ трактор, комбайны нүргээн, тарианы шаргиа, будааны асгаран буух чимээ, залуусын хөгжөөн цэнгээн, будаа цэвэрлэгч машинуудын түжигнээн энэ бүхнийг их ашиглана. Нөхдүүд нь “Дамбаа угаалгын өрөөнд цоргоор ус гоожуулан будааны асгарах чимээг, хөгшнийхээ оёдлын машин шаржигнуулан комбайны дууг орлуулдаг” гэж хошигноно. Энэ нь дэгс үг ч сонсогчдын чихэнд амьдралыг амилуулахын төлөө дуу чимээгээр “дүрс зурж” байгаа зүтгэлийг нь үнэлсэн хэрэг. Ер нь радиогийн уран бүтээлчид Цэдэндамбаагийн сэтгэлийн хөөрөлтэй яриаг сонсох сайхан, цаасан

дээр нь бичсэнийг унших амтгүй гэж ярилцдаг. Тойрч суугаад амыг нь халааж, уран бүтээлийн халуун яриаг өрнүүлэх дуртайсан. Тэрбээр “аппаратандаа матуулсан түүхээ” ч тоохгүй ярина.

“Радиогийн бүдүүн дуут” хэмээн сонсогч түмэндээ алдаршсан Б.Цэдэндамбааг тэр үед танихгүй хүн ховор байлаа. Радиогийн микрофон барихаараа онгод нь нэг ордог, намар болж ургац хураах үеэр бас нэг онгод нь ордог тийм л сэтгүүлч явав. Нэг удаа Зүүн бүрэнгийн САА-гаас буцаж явжээ. Тариагаа эрт хурааж дуусгасан хамт олны ургацын баярт оролцоод нэлээд дөрөө чангалсан байж. Машин шинэ, жолооч залуу, зам сайхан, шидэж гарчээ. Үүрч явдаг үнэнч туслагч хар аппаратаа /радиогийн репортор/ доргилт донсолгооноос хамгаалаад өвөр дээрээ тавьчихсан явлаа. Нэлээд давхиж явснаа “Зогс, морь харъя” гэж жолоочдоо тушаал буулгав. Жолооч ч зогсож мань эр буужээ. Дамбаа морь харах хооронд мотор нь халсан учир жолооч нь машинаа эргүүлэн салхи сөрөөд зогсож байж. Дамбаа гуай иртэл жолооч нь машинаа эргүүлэн замдаа орох гэтэл мань эр,

-Хүүш чи хаачих нь вэ? гэж асуув.

-Сая мотороо хөргөх гээд эргээд зогссон, одоо замдаа орёе гэж жолооч учирлалат,

-Чи хаашаа нөхөр вэ? Ургацын чухал нэвтрүүлэг тасалдуулах санаа байна уу, чигээрээ яв. Би мэдэж байна гэв. Хээрийн замд ном дүрэм ярьсанд шазруун жолоочийн эгдүү хүрч буцаад давхижээ. Үүр манхайн цайж байтал мань хоёр Зүүнбүрэндээ буцаж орж иржээ. Цэдэндамбаа уурлан,

-Энэ чинь юу гээч болж байна гэхэд жолооч учрыг тайлбарлав. Чадсан

чадуулсан хоёр буцаад давхихаас өөр ямар ч арга байсангүй. Ийнхүү будилж явах хооронд ургацын тээв-рийн жолооч замын хажуу талаас Цэдэндамба гуайн аппаратыг олж дор нь таниад Монголын радио дээр хүргэж өгчээ. “Машин нь саатаад замын жолоочоор аппаратаа явуулж. Ийм л хариуцлагатай хүн дээ” хэмээн редакцийнхан баярлан хуурцгийг нь том рулон хальсанд буулгахаар монтажийн операторуудад өгчээ. Тэд хуурцагнаас бүгдийг нь сонсоод /бичлэгийн техникийн түвшин хянадаг учир/хуулж байтал нэлээд халуухан бичлэг гарч ирэв. Эхлээд ажил төрлийн сайхан ярилцлага хөвөрч, ар гэр амьдрал уруу орсноо “Ургацын далай” нэвтрүүлэг олон хүнийг аймаг, улсын аварга, гавьяат тариаланч, тэр ч бүү хэл, хөдөлмөрийн баатар болгосон. Энэ жил тийм ийм САА-н тэр тэр нар бат. Тэр дундаа танай авгай найдвартай гэх маягтай ярьж “За нэг хийчих” хэмээн сүр хүчээ бадруулахад цаана нь хол холхийх шингэн зүйлийн чимээ, шил, шаазан-гийн харшаан сонсогджээ. Яг энэ үеэр радиогийн нэгэн том дарга ороод ирэв. Оператор хүүхнүүд сандралдан төхөөрөмжөө зогсоотол сэжиг авсан дарга ширүүлэн “Цааш нь сонсго” гэжээ. Ингээд хөөрхий Цэдэндамба сэтгүүлч томилолтоосоо ирэхээсээ өмнө ажлаасаа халагдаж **“Үйлс заяа доройтоод ирэхээр үүрч явдаг аппарат хүртэл матчихдаг юм байна”** хэмээн дуу алджээ. Алдсан эндсэн үедээ ч гэсэн өөрийгөө шоглон онож хэлсэн үг нь дал, наяд оны сэтгүүлчдийн дунд дуулиан болон сонсогдож “Аппа-ратандаа матуулсан хүн”<sup>2</sup> нэртэй олон жил явсан. Ард олон, радиогийн үнэнч сонсогчид Цэдэн-дамбаагийн хүнгэнэсэн дуу хоолой,

хэрэгцээ тулсан үед гайхалтай онож хэлдэг үгийг үгүйлдэг.

*“Тэрбээр нэгэн удаа “Ургацын далай” нэвтрүүлэг бэлтгэж яваад нэг айлд ортол хойроор нь дүүрэн зулсан хүүхдүүд хучлагатай хучлагагүй дээш доош харан унтаж байгааг харсан сэтгүүлч “Хн, энэ амьтсыг хөөрхий, задлаад тавьсан шпрод шиг” гэж нүдэнд харагдтал өгүүлсэн байна. Энэ бол нэлээд шинэ үеийн дүрслэл. Гэхдээ лаазалсан бүтээгдэхүүн хэрэглээ бий болсон цагтай уялдуулаад бодоход бас ч тийм шинэ үе биш юм. Тэрбээр муу муухай зүйлийг ч уран хэлээд олныг баясгаж явдаг сэтгүүлч байлаа. Нэлээд хэдэн өдөр хөлчүүрч, нанчид хүртсэний дараа “Ай, долоо хоног өдөр шөнөгүй архи гударлаа. Ам гэж арван гахайны байр.Авах юм алга” гэжээ. Нээрээ олон хоног архи уусан хүний амнаас юун олигтой үнэр гарах билээ, түүнийг арван гахай хахсан пүнзний үнэртэй адилтгэсан нь гайхалтай оновчтой илэрхийлэл юм. Хог шиг, ялгадас шиг гэж зүйрлэвэл гоо сайхны утга учраа алдахаар ядмагхан сонсдох атал, арван гахайны байр гэж хэлсэн нь ихээхэн “соёлтой” аль ч улс оронд байдаг ахуй амьдралын жирийн зураглал санагдаж байна”<sup>3</sup>.*

**Н**ийгмийн сүлжээний том “авдарт” Дамбаагийн тухай бичвэр хэр зэрэг байна хэмээн “Гүүгль” /[www.google.mn/](http://www.google.mn/) хэмээгч металл хайгч багаж шиг хурдан эрэгчээр хайвал Л.Мөнхтөрийн бичсэн “Ярьдаг роман буюу Базарын Цэдэндамбаа” хөрөг бичвэр гарч ирэв.

*“Монгол улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол аваад ирэхдээ анхны сурвалжлага өгөхдөө “Монголын радиог сонсоогүй чих байхгүй”*

хэмээн хэлсэн юм. Одоо харин эрхэм багштан минь тэнгэрийн орноос энэ алдарт үгээ хэлэхээр буцсан. “Ургацын далай” хэмээх нэвтрүүлгийн нэрийн хуудас, нэр нүүр нь болсон энэ аргил хоолой тэнгэрийн хязгааргүйд түгээх болсон...Тэгээд ч хорь шахам жилийн тэртээ Монголын радиогийн “Бүдүүн дуут” хэмээн үзэг нэгт, нэг өрөөнд өргөөлөн суудаг асан МУ-ын Соёлын гавьяат зүтгэлтэн “Болор цом”-ын хошой шагналт, яруу найрагч Цэндийн Чимэддорж бичиж байлаа.

Намайг

Бээжинд сууж ахуйд бичсэн нэг захидал-даа:

“...Энэ хаврын тариа-лалт яахав дээ болд-гоороо л болох биз. ОХУ-аас Саратов-29 сортын баахан үр ирлээ. Одооноос эхэлж өнөөх л үр дүнгүй зөвлөлгөөн эхэлж байна. Байдал иймшүүхэн...

Богд хан уул байрандаа дүнсийж, бохир долоон гудамж наймаачнаар хахаж, зах болгонд заль мэх, заваан хэл ам буцалсаар л чамайг угтах болно. Баяртай сайхан уулзая...

Багшийнхаа тухай бичиж буй энэ л дурсамж хөргөө түүний тухай ярьдаг нэгэн хошин яриагаар өндөрлөө. -Их дэлгүүрт явж байсан чинь, таньдаг нөхөр маань тааралдаад “Миний энэ швейцарь цаг гэж байна. Тэгэхээр нь би өөрийн зүүж явсан хөх нүүртэй “Командирские” гэдэг орос цагаа түүнд харуулж:

-Чи миний энэ цагийг юу гэж санана. Усны хамгаалалттай. Доргионы хамгаалалттай гэх мөртөө аваад шал руу чулуудчихлаа. Золоор хагарсангүй. Хөх пааланд нь жаахан сэв сууж. Өөр эвдрэлгүй шүү. Тэгээд түүнийгээ тайлбарлалаа. Энэ жаахан цайр нь холцорсныг харав уу, чи Манайх Шадивлангийн зусланд байлаа. Нэг халуун өдөр очоод хүйтэн усаар толгой цээжээ булхаад гэртээ орлоо шүү. Удсангүй л авгай хүүхнүүд “цамц, цамц” гээд шуугиан тарилаа

даа. Гараад хартал миний хэцэн дээр тайлаад орхисон цамцны хормой бярууны амаар ороод дуусаж байх нь тэр гэм. Тэгж байтал намар болж хүйтэн сэрүүн эхэллээ. Зуслангаас орох гээд бэлтгэгчихсэн. Энэ муу ганц бярууг хэн харах билээ. Алж аваад орьё гэж бодлоо. Ёсоор болгож байтал, бас л авгай хүүхнүүд

шуугиад явчихлаа. “Цаг цаг... “ л гэж байна. Тэгсэн нөгөө бярууны чинь гүзээнээс миний энэ муу командирский гараад ирдэг байгаа. Зун нөгөө цамцны халаасанд хийгээд хамт идүүлчихсэн юм л даа. Цагаа аваад хартал ертөнцийн цагнаас гуравхан минут хоцорсон байсан шүү...гэж ярьсан гэдэг.<sup>4</sup>

Өнөөдөр сонсогч олон Базарын Цэдэндамбаа агсан шиг дүрсэлж ярьдаг, оюун бодолд зураглал, дуу чимээ, хөгжим хэмнэлтэйгээ шингэж үлддэг тийм яриа, сурвалжлага

«

**Өнөөдөр сонсогч олон Базарын Цэдэндамбаа агсан шиг дүрсэлж ярьдаг, оюун бодолд зураглал, дуу чимээ, хөгжим хэмнэлтэйгээ шингэж үлддэг тийм яриа, сурвалжлага нэвтрүүлгийг үгүйлж байна. Энэ чиглэлийг хөгжүүлэх, сэтгүүлчдийн ур чадвар, ярих урлагийг дэлгэрүүлэх, ард олны дундаас аман билгээрээ шалгарч цолгорсон хүмүүсийг түлхүү оролцуулж байх хэрэгтэй**

»

нэвтрүүлгийг үгүйлж байна. Энэ чиглэлийг хөгжүүлэх, сэтгүүлчдийн ур чадвар, ярих урлагийг дэлгэрүүлэх, ард олны дундаас аман билгээрээ шалгарч цолгорсон хүмүүсийг түлхүү оролцуулж байх хэрэгтэй. Радио бол ихэнх бүтээлээ агаарт цацаж тараадаг хэрэгсэл. Иймээс сайн сэтгүүлч, дүрслэл сайтай яриа бичвэрүүдийг бичиглэж үлдээх, сурах бичиг, хэвлэлд олонтаа оруулж байх хэрэгтэй. Энэ талаар зохих шатныхан анхаарвал зохилтой. Сайхан үг санаанаас гардаггүй гэж монголчууд хэлцдэг. Тиймээс сонсоод уйдамгүй тийм яриаг аль болох олон түмний сонорт хүргэх, хэрэглээнд оруулах, аман билгийн ардын авьяастнуудыг шалгаруулдаг, үг хөгжлийн наадам зохион шагнаж урамшуулдаг ч байж болох юм.

#### Ишлэл

- <sup>1</sup> Цоодол.Д. “Хонины боол” УБ., 2008, х.71-72
- <sup>2</sup> Батжаргал.Д. “Аппаратандаа матуулсан хүн” Сэтгүүлч сэтгүүл 2001 № 04, 05 х.40

- <sup>3</sup> Батжаргал. Д. “Ардын хэлний амт” ЭШӨ. МУИС “Mongolia: Area and culture studies” Vol. 3 /421/, 2015 page.184
- <sup>4</sup> Мөнхтөр. Л. “Ярьдаг роман буюу Базарын Цэдэндамбаа” www.mnb.mn

#### Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Батжаргал. Д. “Аппаратандаа матуулсан хүн”. Сэтгүүлч сэтгүүл. 2001 № 04, 05
2. Батжаргал. Д. “Ардын хэлний амт” өгүүлэл. МУИС “Mongolia: Area and culture studies” 2015. Vol. 3 /421/
3. Мөнхтөр. Л. “Ярьдаг роман буюу Базарын Цэдэндамбаа”
4. Цоодол. Д. “Хонины боол” УБ., 2008

#### Резюме

В статье автор затрагивает тему выразительные средства радиовещания. Для радиожурналиста необходимо освоить выразительные средства, так как главным путем распространения информации для этого вида СМИ является радиоволны. Автор подчеркивает что, надо акцентировать внимание на выразительные средства радиовещания в учебниках, в учебных пособиях посвященные радиожурналистике.